



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
 ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
 ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
 ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
 ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
 ЗАСАГ ДАРГЫН
 ЗАХИРАМЖ**

2022 оны 08 сарын 17 өдөр

Дугаар Б/518

Алтай хот

Гэрээ шууд байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.1, 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалт, Үнэлгээний хорооны 2022 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн 93 дугаар зөвлөмжийг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1.Орон нутгийн хөгжлийн сан болон Нэгдсэн Үндэстний байгууллагын Хүүхдийн сангийн санхүүжилттэй ГААОНӨГ/202204077 дугаар бүхий Монгол гэрийн халаалт, дулаалга, агаар сэлгэлт, шүүгээний багц ажлын халаалтын ажлын Багц1, Цахилгаан халаагуур нийлүүлэх ажлыг гэрээ шууд байгуулан гүйцэтгүүлэх эрхийг Аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Батзориг)-т олгосугай.

2.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулан гүйцэтгэлийг тайлагнаж ажиллахыг Аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Батзориг)-т үүрэг болгосугай.

3.Ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Г.Хурцгэрэл), Чанарын хяналтын баг (Л.Хаш-Эрдэнэ)-т тус тус даалгасугай.

ОРЛОГЧ



Г.ЧИНБАТ

C:/My documents/ZAHNR-3A-4 doc

0201001744